



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОМА-2023/05/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Даланзадгад хот 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn Аудитор: С.Одончимэг Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.03.24 № 275

танай _____-ны № _____-т

ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗАСАГ
ДАРГА Х.БАТБОЛД ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Даланзадгад сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Даланзадгад сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлын онцолсон хэсэг

Даланзадгад сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 7/4 дүгээр “2022 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоолоор сумын төсвийн орлогыг 15,639.7 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 18,716.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн, улмаар аймгийн төсөвт 5,746.8 сая төгрөг төвлөрүүлж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Малын тоо толгойн албан татварын орлогыг төсөвт төвлөрүүлж ажиллаагүйгээс орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэхээр төлөвлөсөн бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хашаа хороо ариутгал хийх, малчдад зориулсан сургалт, сурталчилгаа хийх зэрэг ажлууд тайлант хугацаанд хийгдээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 2/3 дугаар тогтоолоор Даланзадгад сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Дэвшилтэд

016000070

Даланзадгад” хөтөлбөрийг батлан сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 7 хөтөлбөр хэрэгжүүлэн 1,875.5 сая төгрөгийн хөрөнгө зарцуулж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		8,295,932.7	8,587,130.1
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	2,496,782.1	4,476,538.5
АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	1,637,007.6	797,257.0
УРЬДЧИЛГАА	7а, 7б	6,144.9	0.0
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	3,283,723.2	2,109,103.8
НӨӨЦИЙН БАРАА	9а	0.0	0.0
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	872,274.9	1,204,230.7
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		180,026,446.0	129,112,182.0
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	180,026,446.0	129,112,182.0
Газар		0.0	0.0
Биет хөрөнгө		173,931,388.7	128,077,078.9
Биет бус хөрөнгө	13	6,095,057.2	1,035,103.1
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		188,322,378.7	137,699,312.1
НИЙТ ӨР ТӨЛБӨР		393,412.7	626,390.0
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	393,412.7	626,390.0
Өглөг	17а, 17б	29,763.5	101,370.2
Урьдчилж орсон орлого	18а, 18б	363,649.2	525,019.8
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		187,928,965.9	137,072,922.1
Засгийн газрын хувь оролцоо		187,928,965.9	137,072,922.1
Засгийн газрын оруулсан капитал		40,330,993.4	27,850,010.7
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		40,330,993.4	27,850,010.7
Өмч /төрийн/ /ТӨҮГ/		768,388.0	484,597.4
Хуримтлагдсан үр дүн		140,217,713.1	108,563,499.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		6,611,871.5	174,814.9
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		188,322,378.7	137,699,312.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		40,310,354.9	33,485,377.8
ТАТВАРЫН ОРЛОГО		542,208.2	17,235,449.2
Орлогын албан татвар		177,562.9	16,314,618.1
Хувь хүний орлогын албан татвар		177,562.9	17,205,275.9
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		0.0	-890,657.7
Хөрөнгийн албан татвар		8,816.2	519,970.9
Бусад татвар, төлбөр, хураамж		355,829.0	400,860.2
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	15,409,842.7	14,802,935.4
Нийтлэг татварын бус орлого		15,029,841.7	14,551,079.6
Хөрөнгийн орлого		380,001.0	251,855.8
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		24,358,304.0	1,446,993.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	47,656,663.4	34,372,850.3
УРСГАЛ ЗАРДАЛ		47,656,663.4	34,372,850.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		38,621,089.8	26,659,036.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		12,544,143.0	3,987,604.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,746,279.9	509,711.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,166,352.7	1,406,223.2
Хангамж, бараа материалын зардал		1,440,455.3	694,603.7
Нормативт зардал		2,020,917.4	454,712.5
Эд хогшил, урсгал засварын зардал		304,464.1	465,248.6
Томилолт, зочны зардал		5,626.0	21,996.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,487,940.0	3,615,914.1
Бараа үйлчилгээний бусад зардал		17,904,911.4	15,503,021.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		9,035,573.6	7,713,813.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.0	0.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		-7,346,308.5	-887,472.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		0.0	0.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		1,085,386.0	8,206,631.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-8,431,694.5	-9,094,104.1

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	187,928,965.9	0.0	187,928,965.9
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-41,761,939.7	0.0	-41,761,939.7
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	146,167,026.2	0.0	146,167,026.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0
Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	-9,094,104.1	0.0	-9,094,104.1
2022 оны 12-р сарын 31-аарх үлдэгдэл	137,072,922.1	0.0	137,072,922.1

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	29,892,956.3	24,246,699.9
ТАТВАРЫН ОРЛОГО	542,208.2	17,235,449.2
Орлогын албан татвар	177,562.9	16,314,618.1
Хувь хүний орлогын албан татвар	177,562.9	17,205,275.9
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-890,657.7
Хөрөнгийн албан татвар	8,816.2	519,970.9
Бусад татвар, төлбөр, хураамж	355,829.0	400,860.2
Бусад нийтлэг төлбөр, хураамж	280,634.6	193,252.0
Газрын төлбөр	72,542.2	206,294.6
Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,652.2	1,313.5
Бусад татвар	0.0	0.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,955,250.0	5,573,100.1
Нийтлэг татварын бус орлого	4,575,249.0	5,321,244.4
Хөрөнгийн орлого	380,001.0	251,855.8
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	24,395,498.2	1,438,150.6
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,840,819.7	19,114,579.8
УРСГАЛ ЗАРДАЛ	28,840,819.7	19,114,579.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,775,712.4	11,323,272.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,559,519.5	4,008,082.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,737,117.5	523,739.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,174,115.9	1,423,675.8
Хангамж, бараа материалын зардал	596,036.5	757,918.2
Нормативт зардал	530,095.7	281,822.8
Эд хогшил, урсгал засварын зардал	313,753.6	477,740.5
Томилолт, зочны зардал	5,626.0	21,996.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,242,639.6	3,525,176.1
Бараа үйлчилгээний бусад зардал	1,616,808.0	303,119.7
ХҮҮ	0.0	0.0
ТАТААС	0.0	0.0

УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,065,107.3	7,791,307.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,052,136.6	5,132,120.1
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.0	0.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	646,803.0	3,152,363.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	646,803.0	3,152,363.7
Дотоод эх үүсвэрээр	646,803.0	3,152,363.7
Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-646,803.0	-3,152,363.7
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	405,333.6	1,979,756.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,091,448.5	2,496,782.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,496,782.1	4,476,538.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,316,439.30	13,349,025.72
УРСГАЛ ЗАРДАЛ	13,192,837.60	10,666,290.03
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,533,045.40	9,457,064.38
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,196,650.10	2,996,420.45
Үндсэн цалин	1,996,670.60	1,893,837.31
Нэмэгдэл	633,832.00	575,872.78
Унаа хоолны хөнгөлөлт	422,748.00	419,778.91
Урамшуулал	143,399.50	106,931.46
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	425,300.70	391,070.13
Тэтгэврийн даатгал	286,412.60	265,724.47
Тэтгэмжийн даатгал	31,983.70	29,528.81
ҮОМШӨ-ний даатгал	39,528.60	35,170.52
Ажилгүйдлийн даатгал	6,256.80	6,999.57
Эрүүл мэндийн даатгал	61,119.00	53,646.75
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,687,843.40	1,404,862.05
Гэрэл, цахилгаан	267,924.60	208,450.46
Түлш, халаалт	1,019,195.70	857,252.16
Цэвэр, бохир ус	400,723.10	339,159.43
Хангамж, бараа материалын зардал	624,824.20	599,576.99
Бичиг хэрэг	53,450.00	33,528.45
Тээвэр, шатахуун	392,298.80	391,687.60
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	31,600.00	30,520.71
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	31,000.00	31,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	116,475.40	112,840.24

Нормативт зардал	41,500.00	40,500.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	41,500.00	40,500.00
Эд хогшил, урсгал засварын зардал	491,735.10	488,665.22
Багаж, техник, хэрэгсэл	67,000.00	66,980.89
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,049.10	4,049.10
Урсгал засвар	420,686.00	417,635.23
Томилолт, зочны зардал	21,000.00	15,921.00
Дотоод албан томилолт	21,000.00	15,921.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,484,571.90	3,388,262.47
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,484,571.90	3,388,262.47
Бараа үйлчилгээний бусад зардал	559,620.00	131,786.06
Бараа үйлчилгээний бусад зардал	500,620.00	91,966.92
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	59,000.00	39,819.14
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,659,792.20	1,209,225.65
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,469,892.20	1,026,313.95
Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,469,892.20	1,026,313.95
Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-
Бусад урсгал шилжүүлэг	189,900.00	182,911.70
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,000.00	25,105.97
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	57,400.00	56,066.70
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	102,500.00	101,739.03
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,123,601.70	2,682,735.69
Бусад хөрөнгө	4,123,601.70	2,682,735.69
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	17,316,439.30	13,617,636.15
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	1,146,980.50
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	-	1,146,980.50
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	16,708,527.60	12,310,423.18
Орон нутгийн төсвөөс	15,561,547.10	12,310,423.18
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	1,146,980.50	-
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	607,911.70	160,232.47
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	332,120.50	160,232.47
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	275,791.20	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	275,791.31
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	544,401.74

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	291,170.1
УРСГАЛ ЗАРДАЛ	281,205.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	200,284.7
Хангамж, бараа материалын зардал	8,588.0
Бичиг хэрэг	2,415.0
Тээвэр, шатахуун	6,143.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30.0
Эд хогшил, урсгал засварын зардал	28,828.2
Багаж, техник, хэрэгсэл	3,800.0
Урсгал засвар	25,028.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,063.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,063.5
Бараа үйлчилгээний бусад зардал	107,805.0
Бараа үйлчилгээний бусад зардал	107,805.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,920.6
Бусад урсгал шилжүүлэг	78,894.1
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	78,894.1
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,026.5
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,026.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,964.8
Дотоод эх үүсвэрээр	9,964.8
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,964.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	291,170.1
Нэмэлт санхүүжилтийн орлого	291,170.1
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	254,332.3
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,701.1
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	28,136.7
Хаагдсан данс	
Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 2,373.8 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,827.7 сая төгрөгийн алдааг залруулж ажиллалаа. Үүнд:

- Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд зээлийн хүүгийн авлагыг 60.2 сая төгрөгөөр илүү тайлагнасан
- Орлого үр дүнгийн нэгтгэсэн тайланд үйл ажиллагааны нийт орлогыг 1,109.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 147.8 сая төгрөгөөр тус тус илүү илэрхийлсэн
- Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн санхүүгийн тайланд нийт үйл ажиллагааны мөнгөн орлого, зарлагыг 500.5 сая төгрөгөөр дутуу тайлагнасан
- Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланд хөрөнгийн зардалд 9.9 сая төгрөг тайлагнасан байна

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 546.1 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 468.3 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 77.8 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй байна.

5.2 Албан шаардлага

-Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Нийтийн эзэмшлийн талбайг хэсэгчлэн WIFI орчинтой болгох", "Сургуулиудад шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж нийлүүлэх", "Оюут 7 дугаар багийн хавцгайт хороололд хүүхдийн тоглоомын талбай байгуулах", "4 дүгээр сургуулийн дотуур байр, цайны газрын өргөтгөлийн зураг төсөв боловсруулах" зэрэг хөрөнгө оруулалтын ажил гүйцэтгүүлэх гэрээг 2022 оны 12 сард байгуулж, хөрөнгө зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 "төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх",

-Засаг даргын нөөц сангаас ахмад настанд хүндэтгэл үзүүлэх, зорилтод бүлгийн хүүхэд, ахмад настанд дархлаа дэмжих бүтээгдэхүүн олгох зардалд нийт 67.7 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"

- Сумын ИТХ-ын 2021 оны 3/5 дугаар тогтоолын дагуу малын тоо толгойн албан татварт ногдуулсан 2021, 2022 оны татварын орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй, холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай тухай хуулийн 41.2.1 "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"-д заасантай нийцэхгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн хэрэгжилт, төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Засаг даргын нөөц сангаас хөтөлбөр, төсөл арга хэмжээний шинж чанартай Ирээдүйн эзэд-2, эзэмшсэн мэргэжлээрээ эх нутагтаа ажиллая хөтөлбөр, соёлын бүтээлч сар аян, 2-5 дугаар ангийн сурагчдын шүд эмчлэх зэрэг ажлуудад хөрөнгө зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1 "Нөөц хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулна", Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4 "төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний шинж чанартай зардал гаргахгүй байх, Засаг даргын нөөц сангийн хөрөнгийг зориулалтын дагуу холбогдох арга хэмжээг санхүүжүүлж ажиллах

2. Урсгал зардалтай холбоотой асуудал

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй "Даланзадгадад үйлдвэрлэв", "Дэвшилтэд хотын оюунлаг залуус", "Цэмцгэр Даланзадгад" "Оюуны үр" зэрэг хөтөлбөр, арга хэмжээний хүрсэн үр дүн тодорхойгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.7 "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл арга хэмжээний нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдэд нөлөөлсөн үр дүн, үр өгөөжийг тооцож, хэрэгжилтийг тайлагнах, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 11 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд зээлийн хүүгийн авлагыг 60.2 сая төгрөгөөр илүү тайлагнасан	1	60.2			1	60.2	1	60.2				
Орлого үр дүнгийн нэгтгэсэн тайланд үйл ажиллагааны нийт орлогыг 1,109.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 147.8 сая төгрөгөөр тус тус илүү илэрхийлсэн	1	1,257.1			1	1,257.1	1	1,257.1				
Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн санхүүгийн тайланд нийт үйл ажиллагааны мөнгөн орлого, зарлагыг 500.5 сая төгрөгөөр дутуу тайлагнасан	1	500.5			1	500.5	1	500.5				
Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланд хөрөнгийн зардалд 9.9 сая төгрөг тайлагнасан байна	1	9.9			1	9.9	1	9.9				
Дүн	4	1,827.7			4	1,827.7	4	1,827.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Нийтийн эзэмшлийн талбайг хэсэгчлэн WIFI орчинтой болгох",	1	250.1			1	250.1						

"Сургуулиудад шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж нийлүүлэх", "Оюут 7 дугаар багийн хавцгайт хороололд хүүхдийн тоглоомын талбай байгуулах", "4 дүгээр сургуулийн дотуур байр, цайны газрын өргөтгөлийн зураг төсөв боловсруулах" зэрэг хөрөнгө оруулалтын ажил гүйцэтгүүлэх гэрээг 2022 оны 12 сард байгуулж, хөрөнгө зарцуулсан байна.											
Засаг даргын нөөц сангаас ахмад настанд хүндэтгэл үзүүлэх, зорилгод бүлгийн хүүхэд, ахмад настанд дархлаа дэмжих бүтээгдэхүүн олгох зардалд нийт 67.7 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна.	1	67.7				67.7					
Сумын ИТХ-ын 2021 оны 3/5 дугаар тогтоолын дагуу малын тоо толгойн албан татварт ногдуулсан 2021, 2022 оны татварын орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй, холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.	1	150.5				150.5					
Засаг даргын нөөц сангаас хөтөлбөр, төсөл арга хэмжээний шинж чанартай Ирээдүйн эзэд-2, эзэмшсэн мэргэжлээрээ эх нутагтаа ажиллая хөтөлбөр, соёлын бүтээлч сар аян, 2-5 дугаар ангийн сурагчдын шүд эмчлэх зэрэг ажлуудад хөрөнгө зарцуулсан байна.	1	77.8					1	77.8			
Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй "Даланзадгадад үйлдвэрлэв", "Дэвшилтэд хотын оюунлаг залуус", "Цэмцгэр Даланзадгад" "Оюуны үр" зэрэг хөтөлбөр, арга хэмжээний хүрсэн үр дүн тодорхойгүй байна.	1	0					1	0			
Дүн	5	546.1			1	468.3	2	77.8			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, түүний биелэлт, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, ТТЗ-ийн аудитын дүгнэлт, аудитын дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг тус тус мэдээлээгүй байна.	1	984.6					1	984.6
Дүн	1	984.6					1	984.6

/сая төгрөгөөр/